



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, нийт 303,375,884.40 (гурван зуун гурван сая гурван зуун далан таван мянга найман зуун наян дөрвөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр болон тогтоолд заасан салбарын захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ, ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА

0002807

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт

"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ (төгрөг)
1. Говь-Алтай аймаг дахь салбар							
1	Ниссан навара, 82-06 ГАА, (арал-MNTCCUD40Z0004944)	2010-01-31	103806	42,155,481.45	42,155,481.45		500,000.00
	Дүн			42,155,481.45	42,155,481.45		500,000.00
2. Дорнод аймаг дахь салбар							
2	Ниссан навара, 91-02 ДОА, (арал-MNTCCUD40Z0004941)	2010-01-30	165250	42,155,481.45	42,155,481.45		500,000.00
	Дүн			42,155,481.45	42,155,481.45		500,000.00
3. Завхан аймаг дахь салбар							
3	Ниссан навара, 78-87 ЗАН, (арал-MNTCCUD40Z0006813)	2010.08.05	155240	42,423,360.00	42,423,360.00		500,000.00
	Дүн			42,423,360.00	42,423,360.00		500,000.00
4. Өвөрхангай аймаг дахь салбар							
4	Ниссан навара, 15-74 ӨВР, (арал-MNTCCUD40Z0006810)	2010-08-04	174150	42,423,360.00	42,423,360.00		500,000.00
	Дүн			42,423,360.00	42,423,360.00		500,000.00

5.Сэлэнгэ аймаг дахь салбар						
5	Ниссан навара, 93-44 УНЗ, (арал-MNTCCUD40Z0006177)	2010-06-10	178800	42,423,360.00	42,423,360.00	500,000.00
	Дүн			42,423,360.00	42,423,360.00	500,000.00
6.Төв аймаг дахь салбар						
6	Ниссан навара, 94-94 ТӨҮ, (арал-MNTCCUD40Z0006216)	6/8/2010	179835	45,239,360.00	45,239,360.00	500,000.00
	Дүн			45,239,360.00	45,239,360.00	500,000.00
7.Хөвсгөл аймаг дахь салбар						
7	Ниссан навара,24-04 ХӨВ, (арал-MNTCCUD40Z0004928)	2010-01-31	153126	46,555,481.50	46,555,481.50	500,000.00
	Дүн			46,555,481.50	46,555,481.50	500,000.00
	Нийт дүн			303,375,884.40	303,375,884.40	3,500,000.00 (гурван сая таван зуун мянган)